



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 5/419

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ний өдрийн 69 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих Өвөрхангай аймгийн Тарагт сумын Соёлын төвд тоног төхөөрөмж нийлүүлэх, гадна тохижилт, шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер (ӨВАОНӨГ/20190540)-ийн 1 дүгээр багц Тоног төхөөрөмж нийлүүлэх багцыг 24800000 (хорин дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр Баяннайман ХХК-иар, 2 дугаар багц Гадна тохижилт, шугам сүлжээний ажил багцыг 55000000 (тавин таван сая) төгрөгөөр Вентана констракшн ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100696

D:My Doc. Zahiramj. Zasag darga